



МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrt.d.gov.mn, http://www.mrt.d.gov.mn

2022.07.26 № 03/3435
танай _____-ны № _____-т

Г САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН
ГАЗАРТ

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршиж байгаа үлдэгдлээс хавсралтад заасан "Тоёо" ХХК-д Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-ын 8.6 дахь заалтын дагуу олгох 58,121,439.50 (тавин найман сая нэг зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун гучин есөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн эрхийг зохих журмын дагуу нээж өгнө үү.

Хавсралт.....¹⁸ хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

080002571

Зам, тээврийн хөгжлийн яамны Баталгаат хугацааны Барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах Данснаас Барьцаа хөрөнгө олгох жагсаалт

/төгрөгөөр/

2022.07.26

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	2022 оны эхний үлдэгдэл	2022 онд нэмэгдсэн орлого	2022 онд олгосон дүн	Одоо олгох дүн	Үлдэгдэл	Гэрээний заалт	Шийдвэр
	Эрх нээлтгэх нийт дүн		89,680,552.00	26,562,327.00	0.00	58,121,439.50	58,121,439.50		
1	Эзвийн голын 66.24 у/м төмөр бетон гүүр /Говь-Алтай, Шарга сум/ нэмэлт гэрээ	"Тоёо" ХХК		26,562,327.00		13,281,163.50	13,281,163.50	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.03.14-ны өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-ын 8.6 дахь заалт	Авто зам, замын байгууламжийг байнгын ашиглалтад авах ажлын хэсгийн 2022.06.30-ны өдрийн 06/03/22 дугаартай акт, дүгнэлт,
2	Эзвийн голын 66.24 у/м төмөр бетон гүүр /Говь-Алтай, Шарга сум/	"Тоёо" ХХК	89,680,552.00			44,840,276.00	44,840,276.00		

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Мэдээлэл технологи, стандартын хэлтсийн дарга

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч, ахлах шинжээч

Боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн шинжээч

Э.Мөнхнасан

Г.Алтангэрэл

Н.Баярсайхан



“ТОЁО” ХХК

Улаанбаатар хот, СонгиноХайрхан Дүүрэг
30-р хороо, Хилчин 3-19 тоот
Утас: +976- 99992279
И-мэйл: Toyollc19@gmail.com

2022.07.01 № 1/46
танай _____ -ны № _____ -т

Хүсэлт гаргах тухай

Манай компани нь Говь - Алтай аймгийн Ээвийн голын 66,24 у/м гүүрийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн улсын комиссит хүлээлгэн өгөөд байна.


Иймд уг ажлын гүйцэтгэлийн баталгааг чөлөөлж өгнө үү. Холбогдох материалыг хавсаргав



Ж.ЦЭНД -АЮУШ



БАТЛАВ:



**ЭЭВИЙН ГОЛЫН 66.24 У/М ТӨМӨР БЕТОН ГҮҮР /ГОВЬ-АЛТАЙ,
ШАРГА СУМ/-ЫН НЭМЭЛТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2022 оны 04 дүгээр
сарын 18-ны өдөр


№ 119

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас "ТОЁО" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ дараах зүйлийг Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг тус тус үндэслэн харилцан тохиролцож 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга, зам, замын байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах, замын зураг төсөл боловсруулахтай холбогдсон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2. Захиалагч нь **Ээвийн голын 66.24 у/м төмөр бетон гүүр /Говь-Алтай, Шарга сум/-ын нэмэлт ажлыг** (цаашид "ажил" гэх) 599 599 813 /таван зуун ерэн есөн сая таван зуун есөн есөн мянга найман зуун арван гурав/ төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3. Гэрээний нийт дүн: 599 599 813 төгрөг.
- 1.4. Гүйцэтгэгч нь ажлыг 2022 оны 04 дүгээр сарын ...-ны өдөр эхэлж, 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор захиалагчид хүлээлгэн өгнө.
- 1.5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. /цаашид гэрээний бичиг баримт гэх/. Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Гүйцэтгэлийн баталгаа;
 - Ажил гүйцэтгэх хуваарь.
- 1.6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.
- 1.7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 1.8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэж, зерчил гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.



- 1.9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.10. Ажлын чанарын баталгаат хугацаа 3 жил байх бөгөөд энэ хугацаанд эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд гүйцэтгэгч тал өөрийн хөрөнгөөр 100% хохирлыг барагдуулна.


Хоёр. Бусад зүйл

- 2.1. Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргааныг харилцан ойлголцож, эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 2.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт орох тохиолдолд хоёр тал албан бичгээр зөвшилцөнө.

Талууд:

ЗАХИАЛАГЧИЙН ТАЛААС :

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....  Б.Оюундэлгэр


Бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

.....  Ч.Ренчиндамба


Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, ахлах шинжээч

.....  С.Мяндасмаа

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

.....  Д.Оюунсүрэн

Бодлого, төлөвлөлтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

.....  А.Энхжаргал


Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө-11, Засгийн газрын XIII байр
Утас: 976-62263179
Факс: (976-11) 312315

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТАЛААС:


"Тоёо" ХХК-ийн ерөнхий инженер

.....  Ж.Буянжаргал

"Тоёо" ХХК-ийн ерөнхий нягтлан

.....  Б.Ганцэцэг


Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
3 дугаар хороо, Дунд гол төв,
401 тоот, Утас: 99992279
Харилцагч банк: Голомт банк
Дансны дугаар: 5615108118



БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД



ГҮЙЦЭТГЭГЧ:
"ТОЁО" ХХК-ИЙН
ЗАХИВАЛ



Ж.ЦЭНД-АЮУШ

**ЭЭВИЙН ГОЛЫН 66.24 У/М ТӨМӨР БЕТОН ГҮҮР /ГОВЬ-АЛТАЙ,
ШАРГА СУМ/ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2020 оны 12 дугаар
сарын 31-ны өдөр

№ 288

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас "Тоёо" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ дараах зүйлийг Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцож 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга, зам, замын байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах, замын зураг төсөл боловсруулахтай холбогдсон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2. Захиалагч нь **Эзвийн голын 66.24 у/м төмөр бетон гүүр /Говь-Алтай, Шарга сум/ ажлыг** (цаашид "ажил" гэх) 1 898 748 965 /нэг тэрбум найман зуун ерэн найман сая долоон зуун дөчин найман мянга есөн зуун жаран тав/ төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3. Гэрээний нийт дүн: 1 898 748 965 төгрөг.
- 1.4. Гүйцэтгэгч нь ажлыг 2021 оны 03 дугаар сарын 20-ний өдөр эхэлж, 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор захиалагчид хүлээлгэн өгнө.
- 1.5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. /цаашид гэрээний бичиг баримт гэх/. Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
 - Гүйцэтгэлийн баталгаа;
 - Бусад шаардлагатай баримт бичиг.
- 1.6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд зөрчигдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

288

- 1.7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 1.8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 1.9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.10. Ажлын чанарын баталгаат хугацаа 3 жил байх бөгөөд энэ хугацаанд эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд гүйцэтгэгч тал өөрийн хөрөнгөөр 100% хохирлыг барагдуулна.

Хоёр. Бусад зүйл


2.1. Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргааныг харилцан ойлголцож, эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

2.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт орох тохиолдолд хоёр тал зөвхөн албан бичгээр зөвшилцөнө.

Талууд:

ЗАХИАЛАГЧИЙН ТАЛААС:

Зам, тээврийн хөгжлийн яамны
Авто замын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга


..... Д.Загдрагнаа

Зам, тээврийн хөгжлийн яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын
Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн
хэлтсийн дарга


..... Ч.Ренчиндамба

Зам, тээврийн хөгжлийн яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын
Хуулийн хэлтсийн шинжээч


..... Б.Билгүүн

ХЯНАСАН:


Зам, тээврийн хөгжлийн яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын
Хуулийн хэлтсийн дарга


..... Н.Бат-Эрдэнэ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө-11, Засгийн
газрын XIII байр
Утас: 976-62263179
Факс: (976-11) 312315

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТАЛААС:

"Тоёо" ХХК-ийн ерөнхий
менежер


..... Е.Аюурзана

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
3 дугаар хороо, Дунд гол төв,
401 тоот, Утас: 99992279
Харилцагч банк: Голомт банк
Дансны дугаар: 5615108118
Хаан банк: 5866180026

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын гуравдугаар хавсралт

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН АКТ, ДҮГНЭЛТ

2022 оны 06 сарын 30-ны өдөр

Дугаар 06/03/22

Улаанбаатар хот

НЭГ. Ерөнхий мэдээлэл

1.1 Авто зам, замын байгууламж, объектын нэр: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүр

Зургийн шифр: Г11/2017

Магадлалын дугаар: 86/2021

Хаяг: Говь-Алтай аймаг Шарга сум

1.2 Ерөнхий гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг: “Тоёо” ХХК, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 30-р хороо, Хилчний 3-р гудамж, Хамба-19.
Утас: 99992279, 95091114.

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: 9011330145, 5568781.

1.3 Туслан гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг: байхгүй.

1.4 Зураг төслийн байгууллагын нэр, хаяг: “ГБЭТ” ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Нарны зам дагуу Жигүүр грандын байр
Утас: 99196214, 99116214.

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: 9011013113, 2089491.

1.5 Захиалагч байгууллагын нэр, хаяг: Зам, тээврийн хөгжлийн яам, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-11, Засгийн газрын XIII байр Факс: 976-11-321315.

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: 9070005146, 5634768.

1.6 Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч байгууллагын нэр, хаяг: “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо “ЗТХТ” ТӨҮГ-ын байр, Утас: 70002413, 88107368 Факс: 976-70007636

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: 9013001050, 5645913.

1.7 Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр баталсан А/71 дугаар тушаалаар томилогдсон 13 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг нь Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн /Говь-Алтай, Шарга сум/ барилгын ажлыг ашиглалтад авахад бэлэн болсон тухай

Зөвлөх "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 1/452 тоот мэдэгдлийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдөр шинээр барьсан Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн ажлын чанар, холбогдох баримт бичиг, материалуудтай танилцаж, барилгын ажлын талбай дээр нь ажиллаж, үзлэг шалгалт хийв.

1.8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг Г11-2017 шифртэй зураг төслөөр 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхэлж, 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр барьж дуусгасан байна.

ХОЁР. Ажлын хэсгийн шийдвэр

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлын зураг төсөл, холбогдох баримт бичиг, ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр ашиглалтад авах ажлын хэсгээс **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

2.1 Энэхүү авто зам, замын байгууламж нь зураг төсөл, техникийн шаардлагын дагуу бүрэн хийгдэж дууссан Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг үйлчилгээний зориулалтаар ашиглахад хангасан гэж үзээд захиалагч байгууллага Зам, тээврийн хөгжлийн яам, хариуцагч (ашиглагч) байгууллага болох "Говь-Алтай АЗЗА" ТӨХК-ийн мэдэлд 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрөөс ашиглалтад авахыг зөвшөөрөв.

2.2 Уг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлын үндсэн хөрөнгийг 2,498,348,778 төгрөгөөр үнэлэв.

2.3 Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах болсонтой холбогдуулан Ажлын хэсгээс даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

1. "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын 4 дүгээр хавсралтын В хэсэгт заасан баримт бичгийн бүрдлийг хангаж, техник технологийн хяналтын зөвлөх байгууллагаар хянуулан архивт эх хувийг, үлдсэн хувийг тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч, зам хариуцагч байгууллагад 14 хоногийн дотор хүлээлгэн өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг хийх;

2. Авто замын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэгч, техник технологийн хяналтын зөвлөх байгууллага нь авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш чанарын баталгаат хугацаанд тухайн гүүрэнд илэрсэн зөрчил барилгын ажлын чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтлийг бүрэн хариуцан ажиллах.

3. **Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийг** байнгын ашиглалтад авах ажлын хэсгээс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд тусгагдсан 14 ажлуудыг хийж гүйцэтгэсэн тухай тайлан болон акт баталгаажсан өдрөөс эхлэн чанарын баталгаат хугацааг 3 жил гэж тооцох.

Зам ашиглагч (хариуцагч) байгууллагад:

1. Авто замын тухай хуулийн 27.3-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн паспорт, картыг хянаж, хүлээн авч, бүртгэл мэдээллийн санд баяжилт хийж, холбогдох мэдээллийг жил бүрийн тогтоосон хугацаанд авто зам эзэмшигчид хүргүүлж байх.
2. Авто замын тухай хуулийн 23.3-т заасны дагуу чанарын баталгаат хугацааг дууссанаас хойш авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, арчлалт, засварын ажлыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.
3. Ажлын хэсгийн дүгнэлт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 8 хуудас, өгсөн үүрэг даалгаврын биелэлт 7 хуудас материал, авто зам, замын байгууламжийн баримт бичгийн жагсаалтыг хавсаргав.

ГУРАВ. Дүгнэлтийн баталгаажуулалт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
БАРИГДСАН ЭЭВИЙН ГОЛЫН 66.24 У/М ТӨМӨРБЕТОН
ГҮҮРИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ ДҮГНЭЛТ ГАРГАСАН АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга:

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч



Б.Оюундэлгэр

Нарийн бичгийн дарга:

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

Б.Тийвийшинэн

Гишүүд:

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн, улсын байцаагч



Б.Мөнхбаяр

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Авто хяналтын улсын байцаагч



Ц.Дөлбадрах

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН
ЭЭВИЙН ГОЛЫН 66.24 У/М ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН /ГОВЬ-АЛТАЙ,
ШАРГА СУМ/ БАРИЛГЫН АЖЛЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ГИШҮҮД:

Говь-Алтай аймгийн Засаг
даргын орлогч;




Г.Чинбат

Говь-Алтай аймгийн Мэргэжлийн
хяналтын газрын Авто замын
хяналтын улсын байцаагч;




Г.Мөнхөө

Говь-Алтай аймгийн Шарга
сумын Байгаль орчны хяналтын
улсын байцаагч;




Б.Оюунтүлхүүр

Говь-Алтай аймгийн Цагдаагийн
газрын Замын цагдаагийн
тасгийн дарга, Цагдаагийн
дэд хурандаа;



А.Ержан

“ГБЭТ” ХХК-ийн ерөнхий
инженер (Зураг зохиогч
байгууллагын төлөөлөл);




Э.Тодгэрэл

“Говь-Алтай АЗЗА” ТӨХК-ийн
ерөнхий инженер (Ашиглагч
байгууллагын төлөөлөл);



С.Дугарсүрэн

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын
захирал (Техник технологийн хяналтын
зөвлөхийн төлөөлөл);



Х.Пүрэвжаргал

“Тоёо” ХХК-ийн захирал
(Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл);



Ж.Цэнд-Аюуш

Зам, тээврийн хөгжлийн яамны
Архивын эрхлэгч;



Д.Дэлгэрмаа

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БАРИГДСАН
ЭЭВИЙН ГОЛЫН 66.24 У/М ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН /ГОВЬ-АЛТАЙ,
ШАРГА СУМ/ БАРИЛГЫН АЖЛЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ
№01**

2022.06.14

Говь-Алтай, Шарга сум

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг ашиглалтад оруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022 оны 06 дугаар сарын 14-ний өдөр талбай дээр ажиллан үзлэг, шалгалт хийж, гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр 13:30 цагт Говь-Алтай аймгийн Шарга сум дахь кемпэд хуралдлаа.

ХУРАЛД ОРОЛЦСОН ХҮМҮҮС:

Ажлын хэсгийн дарга:

Б.Оюундэлгэр

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч;

Нарийн бичгийн дарга:

Б.Гийвийшинэн

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн;

Гишүүд:

Б.Мөнхбаяр

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн;

Ц.Дөлбадрах

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Авто замын хяналтын улсын байцаагч;

Г.Чинбат

Говь-Алтай аймгийн Засаг даргын орлогч (Зөвшилцсөнөөр);

Г.Мөнхөө

Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч (Зөвшилцсөнөөр);

Б.Оюунтүлхүүр

Говь-Алтай аймгийн Шарга сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Зөвшилцсөнөөр);

А.Ержан

Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Зөвшилцсөнөөр);

Э.Тодгэрэл	"ГБЭТ" ХХК-ийн ерөнхий инженер (Зураг зохиогч байгууллагын төлөөлөл, зөвшилцсөнөөр);
С.Дугарсүрэн	"Говь-Алтай АЗЗА" ТӨХК-ийн ерөнхий инженер (Ашиглагч байгууллагын төлөөлөл Зөвшилцсөнөөр);
Х.Пүрэвжаргал	"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирал (Техник технологийн хяналтын зөвлөхийн төлөөлөл, зөвшилцсөнөөр);
Ж.Цэнд-Аюуш	"Тоёо" ХХК-ийн захирал (Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл, зөвшилцсөнөөр);
Х.Басан	"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын хяналтын инженер;

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг байнгын ашиглалтад оруулах тухай;

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг байнгын ашиглалтад оруулах тухай Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр баталсан А/71 дугаар бүхий тушаалыг гишүүдэд танилцуулав.

Б.Оюундэлгэр: Ажлын хэсгийн нийт гишүүдэд гүйцэтгэгч, зөвлөхийн зүгээс тус авто замыг зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хэрхэн хийж гүйцэтгэсэн талаар танилцуулга хийнэ үү.

Ж.Цэнд-Аюуш: Манай компани Говь-Алтай аймгийн Шарга сумын Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг 1898.75 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хийж гүйцэтгэх гэрээг 2020.12.31-нд, нэмэлт ажлын 599.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээг 2022.04.28-ны өдрийн 149 дугаартай гэрээг тус тус байгуулсан. 2021 онд гүүрийн барилгын ажлыг эхэлсэн ба гүүрийн ажлыг зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийж гүйцэтгэн улсын комисс ажиллуулж байна.

Х.Басан: Тус гүүрийн барилгын ажил өдөр тутмын хяналтыг "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ хийж гүйцэтгэсэн. Магадлалаар батлагдсан зураг төслийн дагуу 66.24 урттай, 8м гүүрийн зорчих хэсгийн өргөнтэй, 2% гүүрийн зорчих хэсгийн дагуу налуутай, 20 см цементбетон хучилттай ба хуучин гүүрийг буулгах, захын болон завсрын тулгуур, 18ш 21м урттай Т хэлбэрийн дам нуруутай хийж гүйцэтгэсэн.

Асуулт, хариулт:

Ц.Дөлбадрах: Талбайд чанарын хяналт, давтан шинжилгээ шаардлага хангаж байсан уу.

Х.Басан: Хангасан гэж үзсэн тул зөвлөхийн дүгнэлтээ өгсөн. Олон объектод гарсан гд асууж бн гэж ойлголоо. Материалын инженер талбайд ажилласан. Бүх шинжилгээ ЗТХТ-д хийгдсэн.

Б.Мөнхбаяр: Авторын санал байна уу. Зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг автор шийдэх ёстой.

Ж.Цэнд-Аюуш: Автортой ярьсан. Инженерүүд нь гүүрийн ажилтай танилцсан. Гишүүд дэмжвэл бид саналаа өгнө, татгалзах зүйлгүй гэсэн.

Ц.Дөлбадрах: Зохиогчийн хяналт гэж хуульд байхгүй. Зохиогч ажлын хэсэгт оролцохыг хууль дагаж гарсан журамд тусгасан байгаа.

С.Дугарсүрэн: Зарим нэг жижиг ажилбар дутуу хийгдсэн байна. Саналд тусгаад өгье.

А.Ержан: Хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлийг харж ажиллалаа. Гүүрийн хайс, хашлага, түмбэ дутуу байна. Аваар осол гарвал хэн хариуцах вэ? Одоо хийгдсэн түмбэний наалт будгаар хийсэн шаардлага хангахгүй байна.

Ж.Цэнд-Аюуш: Зурганд түмбэ шинээр суулгах ажил байхгүй. Гүүрийн бүх ажил зураг төслийн дагуу хийгдсэн. Хөдөлгөөний аюулгүй байдалд санал нэг байна. Тэмдэг тэмдэглэгээний асуудал бас яригдаж байна. Үүрэг чиглэл өгвөл хийнэ. Гүүрийн явган шат зураг төсөлд байхгүй санаачлан хийсэн.

Ц.Дөлбадрах: Авто замын төсөл, норм дүрмээр түмбэ хийгдэнэ.

Ж.Цэнд-Аюуш: Гүүрийн 2 тал замтай байсан учраас түмбэ тусгагдаагүй байх.

Б.Мөнхбаяр: Далан, хучилт хийгдсэн үү.

Ж.Цэнд-Аюуш: Далан, хучилтын ажил байхгүй.

Б.Оюунтүлхүүр: Асуух зүйл байхгүй.

Г.Мөнхөө: Гүүрийн уртын хэмжээ зөрүүтэй харагдаад байна.

Ж.Цэнд-Аюуш: Ар хана ороод урт бодогдсон байгаа.

Г.Чинбат: Бетоны марк хэдтэй цутгасан бэ? Тулгуур суулт өгсөн үү.

Х.Басан: Өдөр тутам хэмжилт хийсэн. Суулт үүсээгүй. Бетоныг 25,30,40 маркаар цутгасан, орцыг ЗТХТөвд баталгаажуулсан. Хайргыг Дарви сумаас зөөсөн.

Ц.Дөлбадрах: Талбайд хэмжилт хийсэн, бетоны бат бэх үзнэ. Бетоны баталсан рекуст дутуу байна, нөхөж хийх хэрэгтэй. Зөвлөхийн тайланд чанарын дагуу хэдэн давтамжтай шинжилгээ хийсэн бэ? Захиалагчийн хяналтын зардлаар төв хяналтын зөвлөхийн ажлыг хийж гүйцэтгэж байгаа. Зөвлөхийн тайланд чанарын шаардлага хэрхэн хангуулсан талаар тусган дахин шинэчлэх шаардлагатай. Зөвлөх ажлын тоо хэмжээ болгоныг талбайд баталгаажуулан батлах ёстой. Материалуудын иж бүрдлийг ханган ажиллах. Гүүрийн хийцийн хувьд урт, өргөн, төлөвлөсөн түвшинд хүрсэн байна.

Б.Оюундэлгэр: Өвөл халиа тошин 1м орчимд үүссэн байна. Цаашид чанарын шаардлага хангах эсэх талаар?

Х.Басан: Өнгөрсөн жил дулаан байж байгаад огцом хүйтэрч халиа тошин гүйсэн. Дам нуруунд 1.2м зайтай үүссэн. Чанарын шаардлага хангана гэж үзэж байгаа.

Б.Оюундэлгэр: Урсгал залахдаа голын гольдрол эвдэгдсэн зүйл байна уу. Карьерын нөхөн сэргээлтийг шаардлагын дагуу хийж гүйцэтгэсэн үү.

Х.Басан: Тийм зүйл байхгүй. Зөвлөхийн зүгээс шаардлага хангасан гэж үзсэн тул дүгнэлтээ хүргүүлэн комисс ажиллаж байна.

Б.Оюундэлгэр: Ямар баталгаа өгөх вэ?

Х.Басан: Байгалийн хүчин зүйлийг хэлж мэдэхгүй байна. Бусад ажилд чанарын баталгаат хугацаа өгч чадна. Баталгаат засварын хугацаанд ямар нэг зүйл гарсан тохиолдолд хийж гүйцэтгэнэ.

Б.Оюундэлгэр: Хийгдэх жижиг ажлууд нэлээд их байна.

Санал:

Ж.Цэнд-Аюуш: Гүүрийн барилгын ажлыг дуусгаж, зөвлөхийн дүгнэлтээр комисс ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд хил, гааль хаалттай, ковидын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн. ЗТХЯ-ны зүгээс холбогдох газруудад уламжлан асуудлыг шуурхай шийдвэрлэж өгч байсан. Талбайд 15 машин механикч, ИТА ажиллаж, 1 жилийн хугацаанд дуусгасан. Комиссоос өгөгдсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх боломжтой. Энэ гүүрийг чанарын баталгаат түвшинд хийж гүйцэтгэсэн гэж үзэж байна. Гүүрийг ашиглалтад авах саналтай байна.

С.Дугарсүрэн: А0304 дугаартай улсын чанартай авто замд байрлах гүүр баригдсан баяртай байна. Гүүрийн тэмдэг, тэмдэглэгээ, кант, ташуу өнгө зэргийг засах шаардлагатай. Ашиглалтад хүлээн авах саналтай байна.

А.Ержан: Гүүрийн хийцэд хэлэх зүйл байхгүй. Замын хөдөлгөөний аюулгүй байдал хангахгүй аваар осол гарвал хэн хариуцлага хүлээх вэ? Тэмдэгийн хэмжээ жижиг, иш нь 2м-ээс бага, стандартын бус хийгдсэн байна. Тухайн байгууллага хариуцлага үүрэх ёстой. Хурдны тэмдэг буруу, 60км-ээс буурах дарааллаар тавих, Гүүрэнд явган замын гарц тэмдэглэгээ, түмбэ, тэнхлэгийн цагаан зураасыг термопластикаар хийх. Мөн хамгаалалтын хайс хийх шаардлагатай. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулахад татгалзах зүйлгүй.

Б.Оюунтүлхүүр: Ажлын явцад 2 удаа ирсэн. Кемп, гүүр орчмын цэвэрлэгээ зэргийг хийх үүрэг өгөгдсөн. Албан шаардлага биелэсэн. Гүүр олон жил унасан болохоор голын гольдрол өөрчилсөн, нөхөн сэргээлтийг хийх. Нийгмийн хариуцлагын хүрээнд хогийн цэг байгуулж өгөх. Ээв нь ундны усыг булгаас авдаг. Гүний худгыг ашиглалтад оруулж өгнө үү. Мөн энэ чиглэлийн авто замыг барьсан гүйцэтгэгч битумээ газарт булснаас үүдэн хэт хуурайшилт ихтэй үед газрын гадаргаас битум гарч байгаа асуудлыг ухаж аваад шатаах арга хэмжээ авч өгөх талаар тус тус санал гаргаж байна. Ашиглалтад авах саналтай байна.

Ц.Дөлбадрах: БО-ны байцаагчаа, Уул уурхайн хуулинд тусгагдсан асуудлыг Авто замын компанитай ярихгүй, манай хуульд энэ талаар байхгүй. МХЕГ-аас ажлын хэсэг ажиллана, тэр үед энэ асуудлаа ярих.

Г.Мөнхөө: Гүүрийн тэмдэг тэмдэглэгээ, орчны цэвэрлэгээ, давтан шинжилгээний материалыг бүрдүүлэх. Ашиглалтад авах саналтай байна.

Г.Чинбат: Орон нутагт том бүтээн байгуулалтын ажил хийсэн гүйцэтгэгч компани, зөвлөхөд баярлалаа. Бетоны марк хүрэхгүй тохиолдолд эдэлгээний асуудал үүсдэг. Иймд материалын бүрдлийг хангах хэрэгтэй. Гүүрийн хийц сайн болсон байна. Гишүүдийн хэлсэн зүйлтэй санал нэг байна. Хөдөлгөөний аюулгүй байдалд анхаарах. Ашиглалтад авах саналтай байна.

Ц.Дөлбадрах: Талбайд захиалагчийн хяналт хэрхэн хийгдсэн талаар хяналт шалгалт хийхэд лабораторийн материал дутуу байна. Хучилтын хийцийн материал, рекуст, бусад материалуудыг гүйцээж хийх. Түмбэ болон тэнхлэгийн зураас, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийх. Зөвлөхийн тайланг сайжруулж, хийгдсэн ажлыг тоо хэмжээгээр нь тусган оруулах. Ашиглагч байгууллагад гүүрийн паспортыг хүлээлгэн өгөх. Баримт бичгийн иж бүрдлийг сайн хангаж архивт өгөх хэрэгтэй. Эзвийн гүүрийг улсын ахлах байцаагчийн 2015.08.14-ны өдрийн 07/096/ГА-02/63 тоот актаар хөрөнгө шийдвэрлэгдэн засварлах хүртэл хугацаанд хаасан. Авто замын хуулийн 9.1 дэх заалтын дагуу хөдөлгөөнд аюул учирч болох асуудлыг шинэчлэн засварласан тул сэргээх арга хэмжээ авах шаардлагатай. Байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Х.Пүрэвжаргал: Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тал дээр онцгой анхаарах хэрэгтэй. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаагүй бол зам хариуцагч, гүйцэтгэгч байгууллагад хариуцлага тооцохоор байгаа. Тэмдэг, дохионы шон, гүүрийн тэмдэглэгээг стандартын дагуу хийх. Гүүрэнд явган шат нэмэлтээр хийсэн байна. Хайс хийх хэрэгтэй. Өнгөлгөөний бетон засварлах, шүүрүүлэх тор бэхлэх, орчны цэвэрлэгээ, гүүрийн паспорт хийж хүлээлгэн өгөх, архивын иж бүрдлийг хангуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулахад татгалзах зүйлгүй.

Б.Мөнхбаяр: Эзвийн гүүр анх өөр зургаар төлөвлөсөн байсан. Сүүлд зурагт өөрчлөлт ороод ус урсах өргөн, овор хэмжээ зөрүүтэй, үндсэн хийц бүтээцийг өөрчилсөн. Цаашид зураг дордуулж өөрчлөлт хийдэг асуудалд анхаарах хэрэгтэй. Явган зам асфальтбетон хучилттай байсан уу. Гүүрийн нийт бүтээц, явах ангид хялгасан хагарал үүссэн, засаж янзлах. Дам нуруунд чулууны ялгарал, гагнуур, хайсны будаг дутуу, цагаан зураасны муруй засах шаардлагатай. Нийт гишүүдийн саналын дагуу дохионы шон суулгах, орчны цэвэрлэгээ хийх. Голын гольдрол боосон уу, халиа тошинд түр зам нөлөөлөх үү.

Ж.Цэнд-Аюуш: Голын гольдрол боосон зүйл байхгүй. Түр зам нөлөөлөхгүй.

Б.Мөнхбаяр: Зураг зохиогчийн санал заавал авах хэрэгтэй. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авахад татгалзах зүйлгүй.

Б.Оюундэлгэр: Ажлын хэсгийн гишүүдийн саналыг холбогдох норм дүрэмд нийцүүлэн хийж гүйцэтгэх. Архивын иж бүрдлийг хангах. Зөвлөхийн тайланг шинэчилж ирүүлэх. Гүйцэтгэлийн зураг, лабораторийн шинжилгээний иж бүрдлийг гүйцээж хийх. Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналуудын дагуу үүрэг даалгаврын биелэлтийг 14 хоногийн дотор хийж гүйцэтгэн, фото зургаар баталгаажуулан тайланг Захиалагчид ирүүлэх. Зураг зохиогчийн саналыг ирүүлсэн тохиолдолд ашиглалтад оруулахад татгалзах зүйлгүй.

Хуралд оролцсон 11 гишүүн саналын хуудас дээр саналаа бичиж хураалгая. Гишүүдийн саналыг үндэслэн дараах шийдвэрийг гаргаж байна.

Ажлын хэсгийн гишүүд тус бүрийн өгөгдсөн саналын дагуу дараах 14 ажлыг хийж гүйцэтгэсний дараа Улсын комиссын актанд гарын үсэг зурж, Эзвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийг улсын байнгын ашиглалтад оруулах.

Ажлын хэсгээс өгөгдсөн үүрэг даалгавар:

Гүйцэтгэгч "Тоёо" ХХК-д дараах ажлуудыг хийж гүйцэтгэхийг үүрэг болгов.
Үүнд:

Гүйцэтгэгч байгууллагад:

1. Гүүрийн тулгуур, дам нуруу, явах анги болон хучилтын дамжих хавтанд үүссэн ан цав, бетоны хагарлыг зориулалтын цавуугаар гагнаж, засаж янзлах.
2. Гүүрийн төмөр хашлагын гагнуурын ажлыг засварлах, нэмж бэхлэх, будах.
3. Зураг зохиогчийн саналыг цаасаар авах.
4. Зөвлөхийн тайланг дахин боловсруулах.
5. Талбай дээр хийгдсэн давтан шинжилгээний материалуудыг бүрдүүлж хийх.
6. Карьер, кемпийн нөхөн сэргээлт, голын гольдрол болон талбайн хог хаягдлын цэвэрлэгээг бүрэн хийж гүйцэтгэх.
7. Гүүрийн тэмдэг, тэмдэглэгээ, дугуй цохигчийг стандартын дагуу сольж, будах.
8. Гүүрийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр дохионы шон нэмж байрлуулан, стандартын дагуу гэрэл ойлгогчтой хийж гүйцэтгэх.
9. Мэдээллэх тэмдэг-2ш, хориглох тэмдэг-2ш, хурдны дээд хязгаарлалтын тэмдэг-6ш стандартын дагуу байрлуулах.
10. Явган шатанд хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган хайс хийх.
11. Ус шүүрүүлэх хоолойн хаалтыг гагнаж бэхлэх.
12. Гүйцэтгэлийн зураг гарган "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-аар баталгаажуулан мэдээллийн санд оруулах.
13. Ажлын хэсгээс өгөгдсөн үүрэг даалгаврыг зөвлөх "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын хяналтан дор хийж гүйцэтгэн, тайланг фото зургаар баталгаажуулж, Захиалагчид тайланг ирүүлэх.
14. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр журмын 4-р хавсралтын В хэсэгт заасан бүрдлийн дагуу тус төмөрбетон гүүрийн холбогдох материалуудыг ЗТХЯаманд цахимаар, "ЗТХТ" ТӨҮГ-т цаасаар болон ашиглагч байгууллагад хуулбарыг хүлээлгэн өгөх.

Ашиглагч байгууллагад:

1. Ашиглагч нь хариуцагчийг тодорхой болгон харуул хамгаалалтыг байнга ажиллуулах.
2. Гүүрийн 2 талын далангийн хажуу налуу болон хэв гажилтын заадсын резинийг технологийн дагуу байнга цэвэрлэж байх.
3. Гүүрийн арчлалт хамгаалалтын зардлыг орон нутгийн төсөвт тусган арчлалт хамгаалалтыг тогтмол хийж гүйцэтгэж байх.

Ажлын хэсгээс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн дотор ирүүлэхийг гүйцэтгэгч "Тоёо" ХХК, хяналтын зөвлөх "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т тус тус даалгалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн барилгын ажлыг гишүүдийн 91 хувь нь үүрэг даалгаврын биелэлтээр, 9 хувь нь шууд саналаар ашиглалтад оруулах саналуудыг тус тус өгч, үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах.
2. Чанарын баталгаат хугацааг ажлын хэсгээс өгөгдсөн үүрэг даалгаврыг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн дотор хийж гүйцэтгэсэн тайлан болон ажлын хэсгийн акт баталгаажсан өдрөөс эхлэн 3 жил гэж тооцох.
3. Ээвийн гүүрийг улсын ахлах байцаагчийн 2015.08.14-ны өдрийн 07/096/ГА-02/63 тоот актаар хөрөнгө шийдвэрлэгдэн засварлах хүртэл хугацаанд хаасан бөгөөд шинэчлэн засварласан тул актаар сэргээх арга хэмжээ авч ажиллах.
4. Ашиглагч байгууллагаар "Говь-Алтай АЗЗА" ТӨХК.
5. Гүйцэтгэлийн зураг гарган "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-аар баталгаажуулан мэдээллийн санд оруулах.
6. Ээвийн голын 66.24 у/м төмөрбетон гүүрийн холбогдох материалуудын иж бүрдлийг хангаж, бүрэн эхээр нь архивт хүлээлгэн өгөх.
7. Үүрэг даалгавраар өгөгдсөн ажлуудыг зөвлөх "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын хяналтан дор хийж гүйцэтгэн, тайланг фото зургаар баталгаажуулан Захиалагчид ирүүлэх.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

Ажлын хэсгийн дарга:

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч



Б.Оюундэлгэр



Гишүүд:

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн, улсын байцаагч




Б.Мөнхбаяр

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Авто хяналтын улсын байцаагч

Ц.Дөлбадрах

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖСЭН
ЭЭВИЙН ГОЛЫН 66.24 У/М ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН /ГОВЬ-АЛТАЙ,
ШАРГА СУМ/ БАРИЛГЫН АЖЛЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ГИШҮҮД:

Говь-Алтай аймгийн Засаг
даргын орлогч;



Г.Чинбат

Говь-Алтай аймгийн Мэргэжлийн
хяналтын газрын Авто замын
хяналтын улсын байцаагч;




Г.Мөнхөө

Говь-Алтай аймгийн Шарга
сумын Байгаль орчны хяналтын
улсын байцаагч;



Б.Оюунтүлхүүр

Говь-Алтай аймгийн Цагдаагийн
газрын Замын цагдаагийн
тасгийн дарга, Цагдаагийн
дэд хурандаа;




А.Ержан

"ГБЭТ" ХХК-ийн ерөнхий
инженер (Зураг зохиогч
байгууллагын төлөөлөл);



Э.Тодгэрэл

"Говь-Алтай АЗЗА" ТӨХК-ийн
ерөнхий инженер (Ашиглагч
байгууллагын төлөөлөл);



С.Дугарсүрэн

"Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын
захирал (Техник технологийн хяналтын
зөвлөхийн төлөөлөл);



Х.Пүрэвжаргал

"Тоёо" ХХК-ийн захирал
(Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл);



Ж.Цэнд-Аюуш

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
Авто замын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын ахлах мэргэжилтэн



Б.Гийвийшинэн